Өмнөговь аймаг дахь дацан, жастай сүм хийд, хурлыг тодруулан байршлыг газрын зурагт буулган тэмдэглэх асуудалд

Л.Түдэвдагва[1], Б.Гэрэлмаа[2], Н.Ганбат[3], Д.Шагдарсүрэн[1], Ш.Болд[1,2]

[1]Эм зүйн шинжлэх ухааны их сургууль
[2]"Ач" Анагаах ухааны их сургууль
[3]Гандантэгчэнлин хийд
Цахим шуудан: ltudevdagva@gmail.com, Утас: 99949345

Түлхүүр үг:

Эмчийн сургууль
Мамба дацан
Манал
Оточ
Мамба

Товч утга:

Үндэслэл: Монгол Улсын анагаах ухааны түүхэн дэх эмч, маарамба, мэргэдүүд түүхийн хэдий үед чухам ямар бүтээл туурвиж, хэрхэн эрдэм боловсрол эзэмшиж эмчлэн ангааж тэдгээр нь түгэн дэлгэрч байсныг судлан шинжилж тогтоох асуудал уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын томоохон талбар төдийгүй онол, практикийн хувьд ч өндөр ач холбогдолтой болохыг судлаачид олонтаа дурьдсан байна. **Зорилго:** Өмнөговь аймаг дахь Хорьдугаар зууны нэгдүгээр хагасаас өмнө байгуулагдсан дацан, жастай сүм хийд, хурлыг тодруулан байршлыг газрын зурагт тэмдэглэгээний хамт шинээр боловсруулан зурах. **Арга, аргачлал:** Бид судалгаандаа Монгол улсын үндэсний төв архив, Гандантэгчинлэн хийдийн төв архив, Өмнөговь аймгийн төв архив, Уламжлалт анагаах ухааны түүхэн боть зэрэг материалуудыг ашиглан үндсэн хэрэглэгдэхүүн болгон авч эх бичиг, сурвалж бичиг судлалын арга, магадлан жагсаах аргуудыг ашиглан судалгааг хийж гүйцэтгэв. **Үр дүн:** Өмнөговь аймгийн нутагт байрлаж байсан хийдүүдээс Байшинтын хийд, Онгийн хүрээ, Ханын цагаан суварга, Дөчийн хурал, Засгийн шүтээний хийд, Эхэн загийн хийд болон Шилүүстэйн хийд нь мамба дацантай байсан бол Онгийн хүрээ, Шар хулсны хурал нь маналын жас, Байшинтын хийд, Уул жаргалантын хийд, Долоо шар загийн хийд, Ханын цагаан суваргын хийд, Дөчийн хурал, Засгийн шүтээний хийд, Хар ноёны хурал, Дуган голын буюу тойногийн хурал, Баг модны хийд, Цагаан толгойн хийд, Цогзолын хийд, Таван ховоотын хийд, Баруун суу хийд, Сайн бичигт буюу ширээт ламын хийдүүд нь мамбын жас, Сангийн далайн хийд, Агуйн хийд болон Цогзолын хийд нь отчийн жастай байжээ. **Дүгнэлт:** Өмнөговь аймгийн нутагт нийт 46 хийд оршиж байснаас мамба дацантай хийд 7, маналын жастай хийд 2, мамбын жастай хийд 14, отчийн жастай хийд 3 байлаа. Эдгээр Мамба дацан, Маналын жас, Мамбын жас, Отчийн жасууд нь зөвхөн шашны болон соёлын төдийгүй уламжлалт анагаах ухааны чухал төвүүд байсны зэрэгцээ олон зуун жил дамжин өвлөгдөж ирсэн анагаах ухааны сургалт, эмчилгээний аргуудыг хэрэглэж, Монголын уламжлалт анагаах ухааны өвийг хадгалах, хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан байна. Цаашид эдгээр хийдүүдийн уламжлалт анагаах ухаанд гүйцэтгэсэн үүргийг гүнзгийрүүлэн судлах нь Монголын анагаах ухааны түүхийг баяжуулах, хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болох нь бидний судалгаагаар тогтоогдлоо.

Үндэслэл: Уламжлалт анагаах ухааны судлаачид анагаах урлаг, заслын их өв сангаа судлан тогтоож хэчнээн мамба дацантай байсан, хэдэн манал, оточ, мамбын жастай байсныг судлах, 1937 оноос эхлэн хэлмэгдсэн эмч, маарамба нарыг нэрсээр нь тогтоож, намтар, бүтээлийг нь судалж ирээдүй үеийнхээ бахархал болгохын төлөө ажиллах үүрэгтэй юм гэж судлаачид онцлон тэмдэглэсэн байна[1]. Ийм ч учраас

Монгол Улсын 21 аймгаас Өмнөговь аймгийг загвар болгон говиос төрсөн оточ, маарамба, мэргэдүүд түүхийн хэдий үед чухам ямар бүтээл туурвиж, хэрхэн эрдэм боловсрол эзэмшиж эмчлэн ангааж тэдгээр нь түгэн дэлгэрч байсныг судлан шинжилж тогтоох асуудал уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын томоохон талбар төдийгүй онол, практикийн хувьд ч өндөр ач холбогдолтой болохыг судлаачид олонтаа дурьдсан байна. Үүний зэрэгцээ Монгол Улсын 21 аймаг тус бүр хичнээн Мамба дацантай, мамбын, отчийн, маналын жастай байсныг тусгайлан судалсан судалгааны ажил маш ховор төдийгүй эдгээр Мамба дацантай байсан сүм хийд, хурлын байршил, эмчлэн сэргийлэх аргууд, амьтан, ургамал, эрдсийн гаралтай эмийн түүхий эд, тэдгээрийн эм судлал, эм найрлагыг нарийвчлан судлан тогтоох нь цаашид энэ чиглэлээр хийгдэх эрдэм шинжилгээ, судалгаа, болон онол, практикийн ач холбогдолтой байгаа нь энэхүү судалгааны үндэслэл боллоо.[2,3]

Зорилго: Өмнөговь аймаг дахь Хорьдугаар зууны нэгдүгээр хагасаа өмнө байгуулагдсан дацан, жастай сүм хийдийн байршлыг тодруулан газрын зурагт тэмдэглэгээний хамт шинээр боловсруулан зурах.

Арга, аргачлал:

Дроноор зураг авах арга: Бид дрон ашиглан зураг авахдаа тухайн авах цэгтэй уялдуулан хөөргөлтийн өндөр болон өнцгөө нарийвчлан тодорхойлсны дараа тухайн цэгийн зургийн субъектийг тохируулж джойстикийн жигд хөдөлгөөнийг фокус объектоос ландшафт болон ар тал руу шилжүүлэн зураг авч Go-Pro зургийг ердийн DSLR-ээр авсан бусад зурагтай хослуулан ашигласав.

Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга: Бид уг аргаар объектын болон түүний орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг өөрсдийн төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлосон. Ялангуяа Өмнөговь аймагт байгуулагдсан хуучин цагийн мамба дацан болон манал, оточ, мамбын жастай сүм хийд, хурлын нэрс, ангилал, тухайн сүм хийдэд сууж байсан зарим эмч, маарамба нарын нэрсийг тогтооход уг аргыг хэрэглэв.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн: 1. Өмнөговь аймгийн төрийн архив, 2. Архивын ерөнхий газар, 3. Үндэсний номын сангийн архив, 4. Тагнуулын ерөнхий газрын тусгай архивд хадгалагдаж байгаа Өмнөговь аймагт 20 дугаар зууны нэгдүгээр хагасаас өмнө байгуулагдсан сүм хийд, хурлын талаарх архивын материалууд, 5. Өмнөговь аймгийн 15 сум, зарим багийн ахмад настан, лам хувраг нартай уулзаж сүм хийд, хурлын тадаар болон тус суманд амьдарч ажиллаж байсан эрт цагийн эмч, маарамба нарын талаарх аман сурвалжийн эх материалуудыг ашиглав.

Үр дүн: Олон зууны турш Монголчуудын соёл, шинжлэх ухаан, анагаах ухаан, шашин шүтлэг, ахуй амьдралын чухал төв байсаар ирсэн сүм, хийдүүд нь манай өв соёл, түүхийн нэн чухал судлагдахуун болохыг цөөнгүй судлаачид онцлон тэмдэглэсэн баримт байна. Түүхийн нугачаанд Монгол Улсын олон зуун сүм хийдийн дийлэнх нь устаж, ул мөргүй болсон ба “Эрдэнэ Зуу”, “Сангийн далай”, “Гандантэгчэнлин”, “Чойжин ламын сүм”, “Амарбаясгалант” гэх мэт цөөн хийд үлдсэн байна[4]. 1944 онд Гандантэгчэнлин хийдийг, 1990-ээд оноос хойш бусад хэд хэдэн сүм хийдийг сэргээн нээсэн боловч урьдын бодит баримт, түүхэн дурсгал цөөн, их төлөв балгас, туурь төдий, мөн цөөн тооны хүний аман яриа үлдсэн нь түүхэн үнэн гуйвах, цаашид бодит мэдээ баримт улам бүр хомстох эрсдэл бий болгож байна гэж судлаачид тэмдэглэсэн байна[5]. Сүүлийн жилүүдэд эдгээрийн тухай уламжлалт анагаах ухааны судлаачид болон хувь хүмүүсийн цөөнгүй тооны судалгааны ном товхимол хэвлэгдэн гарсаар байгаа баримт байна. Тиймээс бид зарим буруу ташааг ойлголтыг залруулах, газарзүйн солбицлыг орчин цагийн технологийн дэвшил ашиглан зөв тогтоон баримтжуулах, сүм хийд, хурлын сүм хийдийн холбогдох мэдээллийг нэгтгэн газрын зурагт тэмдэглэх, зорилгын хүрээнд 2018 оноос эхлэн Өмнөговь аймгийн сүм хийдийн судалгааг хийж эхэлсэн болно.

Өмнөговь аймгийн газрын зурагт тэмдэглэгдсэн хийдүүд: Уулжаргалантын хийд, Байшинтын хийд, Зооринги хийд, Долоо шар загийн хийд, Овоотын хийд, Ханын цагаан суваргын хийд, Засгийн шүтээний хийд, Цохиотын хийд, Сангийн далай хийд, Эхэн загийн хийд, Агуйн хийд, Баг модны хийд, Цагаан толгойн хийд, Цогзолын хийд, Онгийн хүрээ, Балгасын хийд, Таван ховоотын хийд, Цагаан уулын хийд, Шилүүстэйн хийд, Баруун суу хийд, Сайн бичигтийн хийд, Улаан эргийн хийд зэрэг хийдүүд тус тус газрын зурагт тэмдэглэгдсэн байна.

Өмнөговь аймгийн газрын зурагт тэмдэглэгдсэн хурал: Цагаан дэрсний хурал, Налихын хурал, Зүүн уужмын хурал, Суваргын хурал, Шар хулсны хурал, Баянбулагийн хурал, Дөчийн хурал, Хар ноёны хурал, Ганзагатын хурал, Рашаантын хурал, Уртын хурал, Цалгайн хурал, Дуган голын хурал, Цагаан суваргын хурал, Алаг баяны хурал, Цагаан толгойн хийдийн харьяа Дэмчигийн хурал, Цагаан толгойн хийдийн харьяа Улаан сахиусын хурал, Маанийн хурал, Шар довын хурал, Аврахын хурал, Лүнгийн хурал, Хоолтын хурал, Шар дэлийн хурал, Гоёотын хурлууд зэрэг болно. Сүм хийдийг судлах явцад баримтад дурдагдах сумдын нэрс одоогийн сумдад байхгүй, тухайн үеийн мэдээлэлд мөн өөр өөр янзаар тусгагдсан байв. Тухайлбал: Жавхлант, Буянт-Овоо, Баясгалант, Мөнх-Овоо гэх мэт сумдад байх хийд хурал өөр өөрөөр нэрлэгдсэн байсан ба архивын материалаас үзюэл нийт 52 сүм хийд байсан баримт олдсон ба тус аймгийн 15 сумаас 13 сумын нутаг дэвсгэрт нийт 46 сүм хийд болон туурь байгааг сум тус бүрээр тодруулан газарзүйн солбицлыг орчин цагийн дэвшилтэт технологи ашиглан анх удаа судлан тогтоож баримтжуулав (Зураг 1).



Зураг 1. Өмнөговь аймгийн нутагт XX зууны эхэн үеэс өмнө байгуулагдсан сүм хийд, хурлын тэмдэглээ бүхий газрын зураг

Ингээд бид Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт байгуулагдсан мамба дацан, манал, оточ, мамбын жастай сүм хийд, хурлын туурийн зургийг авч баталгаажуулсны зэрэгцээ байгуулагдсан он цаг, тодорхойлолт, тухайн сүм хийдэд сууж байсан зарим эмч, маарамба нарын нэр, намтар, бүтээлийг тодруулан гаргав. Мөн Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт байгуулагдсан 46 сүм хийд, хурлаас 7 Мамба дацантай, 18 нь Манал, Оточ, Мамбын жастай байсныг тогтоолоо (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Өмнөговь аймгийн нутагт XX зууны эхэн үеэс өмнө байгуулагдсан мамба дацан болон манал, мамба, отчийн жастай сүм хийд, хурлын нэрс

Мамба дацан	Жас		
	Манал	Мамба	Оточ
1. Байшинтын хийд 2. Онгийн хүрээ 3. Ханын цагаан суварга 4. Дөчийн хурал 5. Засгийн шүтээний хийд 6. Эхэн загийн хийд 7. Шилүүстэйн хийд	1. Онгийн хүрээ 2. Шар хулсны хурал	1. Байшинтын хийд 2. Уул жаргалантын хийд 3. Долоо шар загийн хийд 4. Ханын цагаан суваргын хийд 5. Дөчийн хурал 6. Засгийн шүтээний хийд 7. Хар ноёны хурал 8. Дуган голын буюу Тойногийн хурал 9. Баг модны хийд 10. Цагаан толгойн хийд 11. Цогзолын хийд 12. Таван ховоотын хийд 13. Баруун суу хийд 14. Сайн бичигт буюу ширээт ламын хийд	1. Сангийн далайн хийд 2. Агуйн хийд 3. Цогзолын хийд

Хэлцэмж: Бидний судалгааны ажил нь хөдөө орон нутгийн сүм хийд, хурлын судалгааг сум тус бүрээр нэгтгэн, архивын баримт материалаар баталгаажуулж хийсэн анхны ажил бөгөөд одоогийн байдлаар Өмнөговь аймгийн бүх сум хамрагдаад байгаа юм. Судалгааг 2018 оны 9 дүгээр сараас 2019 оны 10 дугаар

сарын хооронд Өмнөговь аймгийн нутагт байгаа 46 сүм хийд, хийдийн туурь дээр очин судалгаа хийж, зураг, бичлэг хийн, газарзүйн солбицол тогтоосны үндсэн дээр Архивын ерөнхий газрын харьяа Үндэсний төв архив, Тагнуулын ерөнхий газрын Тусгай архив, түүнчлэн Өмнөговь аймгийн төрийн архивын 1930-1940-өөд оны үеийн сурвалжаар баталгаажуулсан өнөөгийн мэдлэгийн хэрээр олдсон баримтуудыг энэхүү судалгаанд хамруулж, Монгол бичгээр бичигдсэн эх сурвалжийн гол баримтад тулгуурлан кирилл бичигт хөрвүүлэн ашиглав [6,7,8,9].

1931-1938 оны хооронд Өмнөговь аймагт нийт 41 хүрээ, хийд, хурал үйл ажиллагаа явуулж, татвар төлдөг байжээ. Сэврэй сумын Хоолтын хурал нь хунхууз нарын халдлагад өртсөн, 1921 онд гамингууд буцахдаа сүйтгэсэн байх магадлалтай. Номгон сумын Шар дэлийн хурал 1931 оноос өмнө тарсан, Гурвантэс сумын Гоёотын хурал мөн 1931 оноос хойших татварын баримтад огт бүртгэлгүй, Улаан сахиусын болон Дэмчигийн хурал нь Цагаантолгойн хийдийн харьяанд байсан учир бие даан татвар төлж байгаагүй шалтгаанаар эдгээр 5 хурлыг нийт тооноос хасаж, зөвхөн ерөнхий мэдээллийг оруулсан болно[9]. Бидний судалгаагаар эдгээр 46 сүм хийд, хурлаас Мамба дацантай байсан 7, маналын жастай 2, мамбын жастай 14, оточийн жастай 3 байсныг тус тус тогтоосон. Ингэж тогтоосон Мамба дацан болон маналын, мамбын, отчийн жасын байршлын зураглалыг тэмдэглэгээний хамт газрын зурагт шинээр зурлаа.

XVIII зууны үед Монголын нийгмийн мэдлэг, ухааны салбар бүрд сэтгэлгээний томоохон дэвшилтүүд гарч их, бага таван ухааны орчуулгын ба тайлбар зохиолууд олноороо хэвлэгдэн бараг бүх аймаг, хошуудын сүм, хийдэд тараагдан, судлагдаж байжээ. Эдгээр зохиолуудаас “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн урсгалаар онол, арга зүйн гол удирдлагаа болгосон Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийн томоохон хэсэг Мамба дацан өөрийн өвөрмөц дэг жаягаа алхам бүр шинэчилсээр XXI зуунд золгож иржээ[10]. Гагцхүү эмч бэлтгэж ирсэн хуучин сургуулийн шинжлэх ухааны үндэстэй хэсгийг нь судлан тогтоож, улам цаашид хөгжүүлэх явдал чухал байсаар байна гэж бид үзэж байна.

Дүгнэлт: Өнөө цагийн Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт 20 дугаар зууны дунд үеэс урагш байгуулагдсан хуучин цагийн 22 сүм хийд, 24 хурлын туурийг тодруулан 1:650000:масштабтай байршлын газрын зургийг тэмдэглэгээний хамт шинээр зурж, цаашид сургалт, судалгаанд хэрэглэх боломжийг бүрдүүлэв. Түүнчлэн Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт 20 дугаар зууны дунд үеэс өмнө байгуулагдсан 46 сүм хийд, хурлаас 7 Мамба дацантай, 18 нь Манал, Оточ, Мамбын жастай байсныг тодруулан гаргав.

Ном зүй:

1. *Наранзаяа Л. Улс төрийн хэлмэгдэлд өртсөн эмч, маарамбуудын данс, бүртгэлийг тодруулах нь. Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ, 2016*
2. *Болд Ш, Юү Хуан-гынь, Ну Сон-сү, Жавхлан Б. Говийн маарамбууд ба зарим эмт ургамлууд. УБ, 2021, х.6-7*
3. *Болд Ш, Юү Хуан-гынь, Ну Сон-сү, Жавхлан Б. Говийн маарамбууд ба зарим эмт ургамлууд. УБ, 2021, х.6*
4. *Ганбат Н. Монгол Улсын сүм хийд. XX зууны дунд үе хүртэл. Цуврал 1. Өмнөговь аймаг. УБ, 2020, х.12*
5. *Ганбат Н. Монгол Улсын сүм хийд. XX зууны дунд үе хүртэл. Цуврал 1. Өмнөговь аймаг. УБ, 2020, х.12*
6. *МУУТА, 51, Д-1, ХН-190*
7. *ТЕГ-ын Тусгай архив, ХН-250*
8. *Өмнөговь аймгийн Төрийн архив, СХ-1, Д-1, ХН-27*
9. *Ганбат. Н. Монгол Улсын сүм, хийд. XX зууны дунд үе хүртэл. Цуврал 1. Өмнөговь аймаг. УБ, 2020, х.13*
10. *Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ. ADMON ХХК-ийн Хэвлэх үйлдвэр, 2006*

Identifying and mapping the monasteries and temples with Mamba datsan and treasure house established before the 20th century in Umnugovi aimag

Tudevdagva L[1], Gerelmaa B[2], Ganbat N[3], Shagdarsuren D[1], Bold Sh[1,2]

[1]Mongolian University of Pharmaceutical Sciences
[2]"Ach" Medical University
[3]Gandantegchenlin Monastery
E-mail: ltudevdagva@gmail.com Tel: +976-99949345

Background: In the history of tradional medicine in Mongolia, the problem of researching and determining what kind of works were created by doctors, maarambas, and sages in the history of Mongolia, and how they gained scientific education and spread them, is not only a major field of traditional medicine research, but also high in theory and practice. Researchers have often mentioned its importance. Researchers of traditional Mongolian medicine have been intensively studying how many Medical schools (Mamba datsan), treasure-house of the Manal, Otoch, and Mamba existed in Mongolia before the 20th century in the last 5 years. In addition, research works have been underway to identify the names of the repressed doctors and maarambas since 1937 and to study their biographies and medical works.
Aim: To clarify the location of Datsan and Jastai churches and congregations established before the first half of the 20th century in Mungogov province, along with markings on the map.
Materials and Methods: Within the framework of this research work, we conducted a study for the first time to identify the old Mamba datsan and monasteries with treasure-house of the Manal, Otoch, and Mamba established in Umnugovi aimag, one of Mongolia's 21 Aimags.
Results: In conducting this study, we first compiled a list of the number of Mamba datsan, treasure-house of the Manal, Otoch, and Mamba of the monasteries and temples established in Umnugovi aimag. After that, the GPS navigation determines the geographical coordinates of the monasteries and temples also their location in real-time, including latitude and longitude, at the current time. Then, a 1:650000 scale map of the area was drawn and processed. Finally, the map of the monastery with the mamba datsan, treasure-house of the Manal, Otoch, and Mamba, was taken and verified, and the date of its establishment, description, and the names, biographies, and works of some doctors and maarambas who lived in the monastery were clarified.
Conclusion: In the territory of present-day Umnugovi aimag, 22 old monasteries and 24 temples established since the mid-20th century were identified, and a new 1:650,000 scale map of their location was drawn, creating the opportunity to use them in future training and research.

Keywords: Medical schools, Mamba datsan, Manal, Otoch, Mamba